



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2022/100/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК Утас: 99862066 Цахим хаяг: peakomaudit@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3.Аудитын тайлан.....	12
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.4. Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СЭА	Сэлэнгэ аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.02.25 № СЭА-2022/100-НА-СТА-ТШЗ

танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАРУУНБҮРЭН
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
П.ЭНХТУЯА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	73,832,053.94	71,394,060.24
33	АВЛАГА	550,000.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	550,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	73,282,053.94	71,394,060.24
35100	Түүхий эд материал	777,500.00	626,800.00
35130	Эм боох материал	777,500.00	626,800.00
35400	Хангамжийн материал	72,504,553.94	70,767,260.24
35410	Бичиг хэргийн материал	14,019,669.70	14,532,999.70
35420	Аж ахуйн материал	58,484,884.24	56,234,260.54
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	821,649,775.18	836,078,128.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	821,649,775.18	836,078,128.29
39200	Биет хөрөнгө	799,609,508.54	814,350,361.69
39201	Барилга, байгууламж, орон сууц	705,087,707.00	741,412,729.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(36,976,698.90)	(66,611,966.22)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(14,538,309.48)	(14,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	134,706,447.10	150,153,509.01
39206	Хуримтлагдсан элэгдэл	(99,852,131.13)	(112,801,011.48)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	106,317,513.36	120,873,813.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(51,697,693.78)	(62,098,659.06)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,767,889.00	26,767,889.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,540,693.04)	(3,811,039.56)
39217	Ном	17,772,978.41	20,465,097.64
39300	Биет бус хөрөнгө	22,040,266.64	21,727,766.60
39301	Программ хангамж	1,800,000.00	1,800,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(758,333.36)	(1,070,833.40)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,998,600.00	20,998,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	895,481,829.12	907,472,188.53
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	895,481,829.12	907,472,188.53
51	Засгийн газрын хувь оролцоо	895,481,829.12	907,472,188.53
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	605,059,296.25	605,059,296.25
51200	Хуримтлагдсан үр дүн	(34,256,698.85)	(22,266,339.44)
51210	Өмнөх үеийн үр дүн	(90,191,525.27)	(35,296,698.85)
51220	Тайлант үеийн үр дүн	55,934,826.42	13,030,359.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	324,679,231.72	324,679,231.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	895,481,829.12	907,472,188.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	988,846,332.69	954,169,108.34
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,188,237.70	45,182,328.14
120	Нийтлэг татварын бус орлого	80,188,237.70	45,182,328.14
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	73,308,178.00	43,778,328.14
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,880,059.70	1,404,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	908,658,094.99	908,986,780.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	812,235,200.00	807,614,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	812,235,200.00	807,614,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,423,500.00	7,164,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,795,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,423,500.00	2,369,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,999,394.99	94,207,880.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,999,394.99	94,207,880.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	929,224,791.50	940,059,588.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	929,224,791.50	940,059,588.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	850,567,855.46	863,251,065.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	598,195,236.18	585,496,935.76
210101	Үндсэн цалин	444,812,088.38	453,757,351.84
210102	Нэмэгдэл	102,218,647.83	96,472,805.92
210104	Урамшуулал	51,164,499.97	35,266,778.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,474,447.78	79,040,541.20
210201	Тэтгэврийн даатгал	52,335,600.08	55,167,062.81
210202	Тэтгэмжийн даатгал	6,157,130.93	6,106,969.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,841,702.10	4,737,735.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,194,545.79	1,184,434.12
210205	Эрүүл мэндийн даатгал	11,945,468.88	11,844,338.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,659,394.99	94,207,880.20
210301	Гэрэл, цахилгаан	4,112,223.74	4,398,649.95
210302	Түлш, халаалт	76,973,171.25	80,821,830.25
210303	Цэвэр, бохир ус	8,574,000.00	8,987,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,164,300.00	11,942,088.70
210401	Бичиг хэрэг	306,600.00	223,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,795,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	340,000.00	1,111,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	646,700.00	1,969,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	447,900.00	308,600.00
210408	Бараа материал акталсны зардал	4,623,100.00	6,534,338.70
2105	Нормативт зардал	17,514,260.00	28,244,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	307,100.00	343,300.00
210502	Хоол, хүнс	16,607,160.00	27,900,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	392,000.00	2,050,200.00
210604	Урсгал засвар	392,000.00	2,050,200.00
2107	Томилолт, зочны зардал	252,600.00	262,000.00
210702	Дотоод албан томилолт	252,600.00	262,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,781,300.00	5,032,700.00

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,205,300.00	4,024,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	54,134,316.51	56,974,620.03
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	166,200.00	277,800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,367,400.00	2,104,670.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	51,600,716.51	54,592,150.03
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,656,936.04	76,808,523.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,892,080.00	27,404,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	13,292,080.00	27,004,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	400,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,764,856.04	49,403,723.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,764,856.04	49,403,723.04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	59,621,541.19	14,109,519.41
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,686,714.77	1,079,160.00
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,686,714.77	-
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	1,079,160.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	55,934,826.42	13,030,359.41

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	908,658,094.99	908,986,780.20
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	908,658,094.99	908,986,780.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	812,235,200.00	807,614,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	812,235,200.00	807,614,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,423,500.00	7,164,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,795,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,423,500.00	2,369,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,999,394.99	94,207,880.20
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,999,394.99	94,207,880.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	881,769,594.99	883,744,605.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	881,769,594.99	883,744,605.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	803,543,438.95	806,936,082.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	598,195,236.18	585,986,935.76
210101	Үндсэн цалин	444,812,088.38	454,247,351.84
210102	Нэмэгдэл	102,218,647.83	96,472,805.92
210104	Урамшуулал	51,164,499.97	35,266,778.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,474,447.78	79,040,541.20
210201	Тэтгэврийн даатгал	52,335,600.08	55,167,062.81
210202	Тэтгэмжийн даатгал	6,157,130.93	6,106,969.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,841,702.10	4,737,735.46
210204	Ажилгүйдлийн даатгал	1,194,545.79	1,184,434.12
210205	Эрүүл мэндийн даатгал	11,945,468.88	11,844,338.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	89,659,394.99	94,207,880.20
210301	Гэрэл, цахилгаан	4,112,223.74	4,398,649.95
210302	Түлш, халаалт	76,973,171.25	80,821,830.25
210303	Цэвэр, бохир ус	8,574,000.00	8,987,400.00

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	8,516,400.00	6,867,900.00
210401	Бичиг хэрэг	373,800.00	661,500.00
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,795,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	351,000.00	1,164,150.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,183,700.00	432,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,807,900.00	2,814,100.00
2105	Нормативт зардал	17,800,260.00	29,917,500.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	295,800.00	267,600.00
210502	Хоол, хүнс	16,192,460.00	27,900,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,312,000.00	1,749,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,523,200.00	-
210604	Урсгал засвар	3,523,200.00	-
2107	Томилолт, зочны зардал	252,600.00	262,000.00
210702	Дотоод албан томилолт	252,600.00	262,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,953,300.00	8,153,625.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,377,300.00	7,145,625.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	1,008,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,168,600.00	2,499,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	800,000.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,368,600.00	2,499,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,226,156.04	76,808,523.04
2132	Бусад урсгал шилжүүлэг	13,461,300.00	27,404,800.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	12,861,300.00	27,004,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600,000.00	400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	64,764,856.04	49,403,723.04
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	64,764,856.04	49,403,723.04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	26,888,500.00	25,242,175.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	26,888,500.00	25,242,175.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,888,500.00	25,242,175.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,888,500.00	25,242,175.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,888,500.00	25,242,175.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(26,888,500.00)	(25,242,175.00)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	(90,191,525.27)	839,547,002.70
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	(90,191,525.27)	839,547,002.70
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан	-	-	-	-
8	Зарласан ногдол	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	55,934,826.42	55,934,826.42
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	(34,256,698.85)	895,481,829.12
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	(34,256,698.85)	895,481,829.12
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,040,000.00)	(1,040,000.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	(35,296,698.85)	894,441,829.12
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	13,030,359.41	13,030,359.41
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	605,059,296.25	324,679,231.72	(22,266,339.44)	907,472,188.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	919,952,000.00	852,418,257.16	67,533,742.84	92.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	919,952,000.00	852,418,257.16	67,533,742.84	92.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	888,884,000.00	825,013,457.16	63,870,542.84	92.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	610,660,700.00	585,986,935.76	24,673,764.24	95.96
210101	Үндсэн цалин	416,462,000.00	454,247,351.84	-	109.07
210102	Нэмэгдэл	158,513,700.00	96,472,805.92	62,040,894.08	60.86
210104	Урамшуулал	35,685,000.00	35,266,778.00	418,222.00	98.83
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	84,280,500.00	79,040,541.20	5,239,958.80	93.78
210201	Тэтгэврийн даатгал	58,718,700.00	55,167,062.81	3,551,637.19	93.95
210202	Тэтгэмжийн даатгал	6,390,400.00	6,106,969.82	283,430.18	95.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,112,400.00	4,737,735.46	374,664.54	92.67
210204	Ажилгүйдлийн даатгал	1,278,100.00	1,184,434.12	93,665.88	92.67
210205	Эрүүл мэндийн даатгал	12,780,900.00	11,844,338.99	936,561.01	92.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,892,300.00	94,207,880.20	17,684,419.80	84.20
210301	Гэрэл, цахилгаан	7,936,300.00	4,398,649.95	3,537,650.05	55.42
210302	Түлш, халаалт	94,915,300.00	80,821,830.25	14,093,469.75	85.15
210303	Цэвэр, бохир ус	9,040,700.00	8,987,400.00	53,300.00	99.41
2104	Хангамж, бараа материалын зардал	6,730,100.00	6,730,100.00	1.00	100.00
210401	Бичиг хэрэг	394,500.00	405,500.00	-11,000.00	102.79
210402	Тээвэр, шатахуун	1,800,000.00	1,795,250.00	4,750.00	99.74
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,170,400.00	1,164,150.00	6,250.00	99.47
210404	Ном, хэвлэл	357,200.00	357,200.00	1.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	193,900.00	193,900.00	1.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,814,100.00	2,814,100.00	1.00	100.00
2105	Нормативт зардал	45,163,700.00	29,917,500.00	15,246,200.00	66.24
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	267,600.00	267,600.00	1.00	100.00
210502	Хоол, хүнс	43,147,000.00	27,900,800.00	15,246,200.00	64.66
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,749,100.00	1,749,100.00	1.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	24,799,800.00	24,354,200.00	445,600.00	98.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,000,000.00	14,000,000.00	1.00	100.00
210604	Урсгал засвар	10,799,800.00	10,354,200.00	445,600.00	95.87
2107	Томилолт, зочны зардал	266,600.00	262,000.00	4,600.00	98.27
210702	Дотоод албан томилолт	266,600.00	262,000.00	4,600.00	98.27
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,590,600.00	2,014,600.00	576,000.00	77.77
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,006,600.00	1,006,600.00	1.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,584,000.00	1,008,000.00	576,000.00	63.64
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,068,000.00	27,404,800.00	3,663,200.00	88.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,068,000.00	27,404,800.00	3,663,200.00	88.21
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,668,000.00	27,004,800.00	3,663,200.00	88.06
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	400,000.00	1.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	919,952,000.00	852,418,257.16	67,533,742.84	92.66
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	807,614,100.00	758,210,376.96	49,403,723.04	93.88

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	807,614,100.00	758,210,376.96	49,403,723.04	93.88
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	112,337,900.00	94,207,880.20	18,130,019.80	83.86
320001	Орон нутгийн төсвөөс	112,337,900.00	94,207,880.20	18,130,019.80	83.86
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	651.00	641.00	10.00	98.46
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	52.00	52.00	1.00	100.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	1.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	34.00	33.00	1.00	97.06
620003	Үйлчлэх ажилтан	14.00	15.00	-1.00	107.14
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	546.00	536.00	10.00	98.17
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	546.00	536.00	10.00	98.17
630001	Төрийн өмчит ЕБС	546.00	536.00	1.00	98.17
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	52.00	52.00	1.00	100.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	36.00	36.00	1.00	100.00
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	1.00	1.00	1.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	15.00	15.00	1.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	7,164,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	6,634,025.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	6,634,025.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	495,000.00
210401	Бичиг хэрэг	-	256,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	-
210406	Хог хаягдал, хортон шавж	-	239,000.00
2105	Нормативт зардал	-	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	6,139,025.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	530,775.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	530,775.00
223001	Бусад хөрөнгө	-	530,775.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	7,164,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	7,164,800.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,795,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	2,369,800.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн *Цаашид Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль*/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу Пийк-Ом Аудит ХХК-ны аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк-Ом Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд “Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжин хоцрогдлыг арилгах” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар шинэчлэгдсэн,
- Боловсролын тухай хуулийн 40 дүгээр зүйл.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилттэй холбоотой,
- Сангийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэл, аудитын стандартын хорооны 2020 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан УСНББОУС-ын өөрчлөлт шинэчлэл хийгдсэн .

Байгууллагын үндсэн мэдээлэл, түүний гадаад орчин болон дотоод үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл явцыг судалж, ойлгосноор эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Байгууллагын дотоод хяналтын үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор бус нөхцөл байдалд тохирсон аудитын горимуудыг оновчтой төлөвлөхийн тулд аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголттой болсон. Дотоод хяналтын бүрэлдэхүүн хэсгийн талаар судалж эрсдэлтэй асуудлыг тодорхойлж баримтжуулав.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгдээгүй хийгдээгүй байна.

3.3. Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 929,224.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 9,292.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 буюу 6,504.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,990.30 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үндсэн хөрөнгө, засгийн газрын оролцоо дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-

Авлага	550.00	-	(550.00)
Бараа материал	73,282.00	71,394.00	(1,888.00)
Үндсэн хөрөнгө	821,649.80	836,078.10	14,428.30
Нийт хөрөнгө	895,481.80	907,472.10	11,990.30
Өр төлбөр	-		-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	895,481.80	907,472.10	11,990.30
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	895,481.80	907,472.10	11,990.30

Бараа материалын дансны үлдэгдэл 71,394.0 мянган төгрөг болж 1,888.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 69,054.7 мянган төгрөгийн хүнсний материал, аж ахуйн материал, түлш шатахуун, эм боох материал худалдан авч, ЗДТГ-аас 485.0 мянган төгрөгийн, төгсөгчдөөс 110.0 мянган төгрөгийн, сургуулийн ажилтнуудаас 290.0 мянган төгрөгийн, иргэн Ж.Наранцэцэгээс 350.0 мянган төгрөгийн маск, гар ариутгагч, автомаск, БСГ-аас 169.0 мянган төгрөгийн бараа материал хандиваар авч, 65,812.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 1,097,034.1 мянган төгрөг болж өмнөх оноос 69,020.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 14,000.0 мянган төгрөгийн принтер, хэвлэгч, 887.9 мянган төгрөгийн сурах бичиг худалдан авч, 36,325.0 мянган төгрөгийн засварыг капиталжуулан, БСГ-аас 1,447.0 мянган төгрөгийн хувилагч, компьютер, 14,556.3 мянган төгрөгийн хичээлийн биет хэрэглэгдэхүүн, 1,804.1 мянган төгрөгийн сурах бичиг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэснээс шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 907,472.1 мянган төгрөг болж 11,990.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 954,169.1 мянган төгрөг болж өмнөх оноос 34,577.2 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Энэ нь өмнөх оноос үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 35,005.9 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 940,059.6 мянган төгрөг болж өмнөх оноос 10,834.8 мянган төгрөгөөр буюу 1.16 хувиар өссөн нь норматив зардал 10,729.8 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг тус бүр 928,222,4

мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 8,270.4 мянган төгрөгөөр бууруулж, 919,952.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 919,952.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 807,614.1 мянган төгрөгийг улсын төсвөөс /тусгай зориулалтын шилжүүлгээр/, 112,337.9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 807,614.0 мянган төгрөгийн орон нутгийн төсвөөс 94,207.8 мянган төгрөг, нийт 901,821.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 852,418.1 мянган төгрөгийг зарцуулж, төсвийн зарлагын хэмнэлтийн 49,403.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 852,418.1 мянган төгрөг буюу 92.7 хувьтай тайлагнагдсан нь цалин, хөлс урамшууллын зардлыг 24,673.7 мянган төгрөгөөр, норматив зардлыг 15,246.2 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 17,684.4 мянган төгрөгөөр зардлуудыг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд тендерийн орлого 256.0 мянган төгрөг, түрээсийн номны орлого 2,369.8 мянган төгрөг, БСГ-аас 4,539.0 мянган төгрөг нийт 7,164.8 мянган төгрөг төвлөрснийг бичиг хэргийн зардалд 256.0 мянган төгрөг, хог хаягдлын зардалд 239.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 6,139.0 мянган төгрөг, багаж техник хэрэгслийн зардалд 530.8 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1. Боловсролын сайд болон Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны А/292 А/525 дугаар тушаалаар батлагдсан “Сургуулийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулахад мөрдөх түр журам”-ын дагуу цахим болон танхимын сургалтад шилжүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургуульд 919,952.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 852,418.1 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 6.1 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2019 оны А/60 дугаар тушаалаар “Итгэмжлэл” олгож, Зөрчилгүй санал дүгнэлт өгөгдсөн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

3.11.1 Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5,771.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, 2 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

4.4 Зөвлөмж

1. Бараа материалын тайлантай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Бараа материалын тайланд 1,004.3 мянган төгрөгийн бараа материалыг дансны ангилал буруу бүртгэж тайлагнасан байна

1.2. Өгсөн зөвлөмж: Энэ нь Энэ нь УСНББОУС 12 “Бараа материал”-ын 11-д заасантай нийцээгүй ба “Толилуулга ба тодруулга” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул цаашид бараа материалыг данс бүртгэлд зөв ангилан бүртгэх.

2. Мөнгөн хөрөнгө, жижиг мөнгөн сантай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт: 2021 оны 12 сарын 23-нд мөнгөн кассаар 4,767.2 мянган төгрөгийг дамжуулан зарцуулсан байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Сангийн сайдын 276 дугаар тушаалын 1 хавсралтын 6.2 дахь “төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс хамааран дараах хэмжээтэй байна. Үүнд: / батлагдсан төсөв 100,000,001-1,000,000,000 хүртэлх төгрөг –жижиг мөнгөн сан 500,000-1,500 000 төгрөг/” гэж заасантай нийцэхгүй байгаа тул цаашид мөнгөн кассын хэмжээг баримтлан ажиллах

3. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Шилэн дансанд нийт мэдээлбэл зохих 149 мэдээллээс 140 мэдээллийг хугацаанд нь, 9 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 6.4 гэсэн заалтуудыг зөрчсөн тул холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын ерөнхий боловсролын сургууль	1	5,771.5	0	0	0	0	0	0	3	5,771.5

